



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2021/28/СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2021 он	Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор: Я.Самбууням Утас: 260949 Цахим хаяг: sambuunyamyamya@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: П.Чанцалдулам Утас: 261740 Цахим хаяг: chantsldulamp@audit.gov.mn Аудитор: Ц.Энхжаргал Утас: 261740 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал	11
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	12
3.5.2 Авлага	13
3.5.3 Бараа материал	13
3.5.4 Үндсэн хөрөнгө	14
3.5.5 Өр төлбөр	14
3.5.6 Засгийн газрын хувь оролцоо	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Шилэн дансны мэдээлэл.....	17
3.10Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	19
5. Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	22
6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДС	Нийгмийн даатгалын сан
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
СБХОБ	Санхүү бүртгэл, хамралт, орлого бүрдүүлэлт



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
А.АРИУНЗАЯА ТАНАА

2021.04.26 № 1336
танай _____-ны № _____-т
Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

A handwritten signature in black ink is written over a red rectangular stamp. The signature is stylized and appears to read 'Д.ЗАНДАНБАТ'. The stamp is a red rectangular seal with some illegible text inside.

Д.ЗАНДАНБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,514,972,608.6	2,170,414,011.8
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,262,586,223.8	732,373,194.9
33	Авлага	251,411,258.3	1,436,859,319.4
34	Урьдчилгаа	1,150.5	-
35	Бараа материал	952,376.0	1,159,897.5
360	Бусад эргэлтийн хөрөнгө	21,600.0	21,600.0
2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	35,598,914.1	38,657,522.4
39	Үндсэн хөрөнгө	35,598,914.1	38,657,522.4
39200	Биет хөрөнгө	34,074,290.0	33,887,840.6
39300	Биет бус хөрөнгө	1,524,624.1	4,769,681.8
3	Нийт хөрөнгийн дүн	1,550,571,522.7	2,209,071,534.2
4	Нийт өр төлбөр	21,007,886.6	462,428,466.5
41	Богино хугацаат өр төлбөр	21,007,886.6	462,428,466.5
413	Өглөг	12,880,904.0	451,114,849.4
414	Урьдчилж орсон орлого	8,126,982.6	11,313,617.1
5	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,529,563,636.1	1,746,643,067.7
51	Засгийн газрын хувь оролцоо	1,529,563,636.1	1,746,643,067.7
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,209,752.7	12,216,142.7
512	Хуримтлагдсан үр дүн	1,512,934,560.8	1,730,007,602.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,419,322.6	4,419,322.6
6	Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,550,571,522.7	2,209,071,534.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,845,515,170.3	3,008,066,155.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,148,207,206.4	2,489,702,753.4
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	2,148,207,206.4	2,489,702,753.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	91,590,837.3	65,468,362.1
120	Нийтлэг татварын бус орлого	91,590,837.3	65,468,362.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	605,717,126.6	452,895,039.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,398,936,689.4	2,791,300,699.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,398,936,689.4	2,791,300,699.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,308,095.0	29,075,600.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,370,968.2	19,010,737.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,012,277.0	2,399,107.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,064,823.6	1,085,644.8
2104	Хангамж, бараа материалын зардал	792,472.4	965,504.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	251,542.7	165,752.7
2107	Томилолт, зочны зардал	296,698.1	106,346.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,454,965.4	2,453,901.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,064,347.6	2,888,605.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,372,628,594.4	2,762,225,099.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	446,578,480.9	216,765,455.4
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	987.8	6,013.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	47,163.3	38,505.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	446,532,305.4	216,732,963.0

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,090,690,593.1		1,090,690,593.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-7,658,817.2		-7,658,817.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,083,031,775.9		1,083,031,775.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	445.3		445.3
9	Тайлант үеийн үр дүн	446,532,305.5		446,532,305.5
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,529,563,636.1		1,529,563,636.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	340,078.6		340,078.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,529,903,714.7		1,529,903,714.7
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	6,390.0		6,390.0
19	Тайлант үеийн үр дүн	216,732,963.0		216,732,963.0
20	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,746,643,067.7		1,746,643,067.7

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,827,084,508.7	2,697,725,756.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,127,238,287.0	1,722,226,084.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	2,127,238,287.0	1,722,226,084.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	94,129,095.1	500,545,817.8
120	Нийтлэг татварын бус орлого	94,129,095.1	500,545,817.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	605,717,126.6	474,953,854.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,408,815,061.6	3,227,932,735.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,408,815,061.6	3,227,932,735.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,985,989.4	26,965,951.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,742,248.4	19,049,444.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,079,559.5	2,414,152.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,075,941.3	1,088,995.8
2104	Хангамж, бараа материалын зардал	777,234.6	978,336.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	297,754.9	184,429.6
2107	Томилолт, зочны зардал	296,698.1	106,346.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,391,527.1	3,024,718.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	325,025.5	119,527.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,383,829,072.2	3,200,966,784.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	418,269,447.1	-530,206,978.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	104,214,563.9	6,050.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	104,214,563.9	6,050.0
2200	Дотоод эх үүсвэрээр	104,214,563.9	6,050.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-104,214,563.9	-6,050.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	314,054,883.2	-530,213,028.9
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	948,531,340.6	1,262,586,223.8
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,262,586,223.8	732,373,194.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,262,563,901,238.94		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,494,043,254,600.00	2,451,795,894,977.77	42,247,359,622.23	98.3
УРСГАЛ ЗАРДАЛ	2,494,043,254,600.00	2,451,795,894,977.77	42,247,359,622.23	98.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,481,524,400.00	25,889,446,772.25	592,077,627.75	97.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,213,961,700.00	19,049,444,135.25	164,517,564.75	99.1
Үндсэн цалин	14,057,050,900.00	13,782,571,435.17	274,479,464.83	98.0
Нэмэгдэл	3,753,345,600.00	3,905,145,265.16	-151,799,665.16	104.0
Унаа хоолны хөнгөлөлт	1,182,885,200.00	1,113,915,008.69	68,970,191.31	94.2
Урамшуулал	220,680,000.00	247,812,426.23	-27,132,426.23	112.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,514,332,900.00	2,414,152,277.85	100,180,622.15	96.0
Тэтгэврийн даатгал	1,772,516,600.00	1,630,012,585.92	142,504,014.08	92.0
Тэтгэмжийн даатгал	182,590,400.00	193,692,752.71	-11,102,352.71	106.1
ҮОМШӨ-ний даатгал	146,534,800.00	155,195,373.62	-8,660,573.62	105.9
Ажилгүйдлийн даатгал	37,517,200.00	39,240,423.19	-1,723,223.1	104.6
Эрүүл мэндийн даатгал	375,173,900.00	396,011,142.41	-20,837,242.41	105.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,142,031,200.00	1,088,995,821.06	53,035,378.94	95.4
Гэрэл, цахилгаан	222,540,200.00	206,133,244.12	16,406,955.88	92.6
Түлш, халаалт	674,073,900.00	650,883,743.01	23,190,156.99	96.6
Цэвэр, бохир ус	81,005,100.00	67,566,833.93	13,438,266.07	83.4
Байрны түрээс	164,412,000.00	164,412,000.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	878,641,900.00	863,757,030.39	14,884,869.61	98.3
Бичиг хэрэг	254,513,300.00	253,179,388.00	1,333,912.00	99.5
Тээвэр, шатахуун	295,112,900.00	285,410,591.00	9,702,309.00	96.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	160,929,800.00	158,111,263.39	2,818,536.61	98.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19,641,500.00	18,785,320.00	856,180.00	95.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	148,444,400.00	148,270,468.00	173,932.00	99.9
Эд хогшил, урсгал засварын зардал	144,562,500.00	143,450,513.00	1,111,987.00	99.2
Багаж, техник, хэрэгсэл	90,572,700.00	89,615,958.00	956,742.00	98.9
Урсгал засвар	53,989,800.00	53,834,555.00	155,245.00	99.7
Томилолт, зочны зардал	89,750,200.00	80,618,940.00	9,131,260.00	89.8
Дотоод албан томилолт	89,000,200.00	79,868,940.00	9,131,260.00	89.7
Зочин төлөөлөгч хүлээн авах	750,000.00	750,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,298,726,500.00	2,149,506,190.70	149,220,309.30	93.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,222,223,800.00	1,174,709,129.56	47,514,670.44	96.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	88,316,500.00	86,731,800.00	1,584,700.00	98.2
Даатгалын үйлчилгээ	55,899,400.00	50,230,228.00	5,669,172.00	89.9
Тээврийн хэрэгслийн татвар	6,432,000.00	3,964,987.00	2,467,013.00	61.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	526,924,100.00	525,089,175.79	1,834,924.21	99.7
Газрын төлбөр	12,597,900.00	8,505,066.00	4,092,834.00	67.5
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	297,232,800.00	211,180,804.35	86,051,995.65	71.0

**Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	89,100,000.00	89,095,000.00	5,000.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	199,517,500.00	99,521,864.00	99,995,636.00	49.9
Бараа үйлчилгээний бусад зардал	96,000,000.00	-	96,000,000.00	-
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	103,517,500.00	99,521,864.00	3,995,636.00	96.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,467,561,730,200.00	2,425,906,448,205.52	41,655,281,994.48	98.3
Бусад урсгал шилжүүлэг	2,467,561,730,200.00	2,425,906,448,205.52	41,655,281,994.48	98.3
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,466,464,900,000.00	2,424,813,089,646.52	41,651,810,353.48	98.3
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	282,352,600.00	280,170,830.00	2,181,770.00	99.2
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	810,665,100.00	810,287,729.00	377,371.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,812,500.00	2,900,000.00	912,500.00	76.1
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,494,043,254,600.00	1,878,187,311,452.86	615,855,943,147.14	75.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	399,417,600,000.00	399,417,600,000.00	-	100.0
Улсын төсвөөс санхүүжих	399,417,600,000.00	399,417,600,000.00	-	100.0
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,094,455,654,600.00	1,477,090,706,712.72	617,364,947,887.28	70.5
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,093,355,654,600.00	1,475,990,706,712.72	617,364,947,887.28	70.5
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,100,000,000.00	1,100,000,000.00	-	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	170,000,000.00	1,679,004,740.14	-1,509,004,740.14	987.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,376,991,188.79	-1,376,991,188.79	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	170,000,000.00	302,013,551.35	-132,013,551.35	177.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	732,327,407,781.56	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт		43,372,090,067.53		
БАЙГУУЛЛАГЫН ТОО	35	35	-	100.0
Төсвийн байгууллага	35	35	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	1,436	1,433	3	97.6
Удирдах ажилтан	42	42	-	98.3
Гүйцэтгэх ажилтан	1,209	1,223	14	94.6
Үйлчлэх ажилтан	185	168	-17	118.1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

	Эдийн засгийн ангилал	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	71,371,623,511.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	71,365,573,511.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	253,943,698.05
2104	Хангамж, бараа материалын зардал	114,579,057.10
210401	Бичиг хэрэг	1,639,990.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	330,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	111,109,067.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,550,270.00
210604	Урсгал засвар	39,550,270.00
2107	Томилолт, зочны зардал	428,000.00
210702	Дотоод албан томилолт	428,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	79,380,390.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	79,222,390.95
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	158,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,005,980.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,600,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,405,980.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	71,111,629,813.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,972,326.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	26,478,560.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,493,766.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	71,082,657,487.54
213305	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	71,082,657,487.54
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,050,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,050,000.00
225001	Биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,050,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	71,395,088,026.99
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,395,088,026.99
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	71,099,273,410.04
131103	ЗГНХ,ЗДНХ,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	106,481,415.95
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	189,333,201.00
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	23,464,515.40
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,322,602.09
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	45,787,117.49

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд тухайн жилийн мөнгөн хөрөнгийн хадгаламжид байршуулах мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтоолгох, төсвийн төлөвлөлтийг тооцоо судалгаанд үндэслэх, татаас санхүүжилтийн авлагыг үүсгэхгүй байх, авлагыг бүрэн барагдуулж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор П.Чанцалдулам, аудитор Ц.Энхжаргал нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 1/557 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

НДЕГ-ын эрхэм зорилго нь даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэхэд оршино. Нийгмийн даатгалын байгууллагын үндсэн чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;
- Нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах,
- Нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах;
- Нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;
- Доод шатны байгууллагынхаа үйл ажиллагаанд хяналт тавих,
- Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг болно.

НДЕГ нь 2020 оныг Нийгмийн даатгалын байгууллагын бүртгэл, мэдээллийн чанарыг сайжруулах, үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтын үр дүнг дээшлүүлэх, байцаагч, ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, хариуцлагыг чангатгах зорилгоор нийгмийн даатгалын салбарын хэмжээнд "Нэг бүртгэл-нэг хяналтын жил" болгон зарлажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай;
- Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай;
- Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай;
- Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулиуд болно.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллага нь Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан 2006 оны 18/03 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, санхүүгийн тайлан бэлтгэх заавар”, НДЕГ-ын даргын 2009 оны 396 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журмын өөрчлөлтийг оруулаагүй байна.

Тайлант онд дотоод аудит, мониторингийн газраас 5 чиглэлд аудит хийж, аудитаар илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмжийг өгч ажилласан байна. Үүнд:

- Улсын байцаагчийн актын үндэслэлд хийсэн аудит;
- Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит;
- Төв аймгийн НДХ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудит;
- “Маягт, эмхэтгэл, товхимлын зарцуулалтын журам”-ын хэрэгжилтэд хийсэн аудит;
- “Нийгмийн даатгалын байгууллагуудын автомашин ашиглалтын журам”-ын хэрэгжилтэд хийсэн аудит болно.

Мөн хяналт шалгалтын газраас НДЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Баянгол дүүргийн НДХ, Дархан-Уул, Архангай аймгуудын НДХ-т ажиллаж, 2015–2020 онуудын нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт, зардлын хэтрэлт, хэмнэлт, өр, авлагын барагдуулалт, үйл ажиллагааны зардлын зарцуулалт, анхан шатны баримтын үндэслэл, тэтгэвэр тэтгэмжийн тогтоолт, олголтод тавих дотоод хяналтын үр дүнг шалгаж, нийт 1,939.7 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 20.2 сая төгрөгийн акт, 650.2 сая төгрөгийн зөвлөмж, 35.4 сая төгрөгийн зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлж, 1,233.9 сая төгрөгийн зөрчил шийдвэрлэх шатанд байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2019 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 2,398,936.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 23,989.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тогтоохдоо материаллаг байдлын суурь, хувь хэмжээг өөрчлөхгүйгээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлаас тооцон 27,913.4 сая төгрөгөөр тогтоов.

Энэ нь төлөвлөлтийн шатанд тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэгдээгүй байсан тул материаллаг байдлын түвшинг өмнөх оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр тогтоосонтой холбоотой.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 1,262,586.2 сая, эцсийн үлдэгдэл 732,373.2 сая төгрөг болж, 530,213.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл банкаар /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө			
Төгрөг	1,262,586.2	732,373.2	-530,213.0
Төрийн сангийн харилцах	62,768.8	16,987.8	-45,781.0
Арилжааны банк дахь харилцах	715,515.1	705,280.0	-10,235.1
Нэмэлт санхүүжилтийн харилцах	22.3	45.8	23.5
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	59.6	59.6
Хадгаламж	484,280.0	10,000.0	-474,280.0
Дүн	1,262,586.2	732,373.2	-530,213.0

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 705,280.0 сая төгрөг арилжааны банкны харилцах дансанд, 16,987.8 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, 10,000.0 сая төгрөг хадгаламжийн дансанд, 59.6 сая төгрөг замд яваа мөнгө, 45.8 сая төгрөг нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос буурсан нь тайлант онд Коронавируст цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого буурсан даатгуулагчдыг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх хууль батлагдан гарсантай холбоотойгоор албан журмын болон сайн дурын даатгуулагчдаас төлөх нийт 642,589.4 сая төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлсөн нь нөлөөлжээ.

Мөнгөн хадгаламжийн эхний үлдэгдэл 484,280.0 сая төгрөгөөс 10,000.0 сая төгрөг болж буурсан нь Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасны дагуу арилжааны 8 банканд 694,721.9 сая төгрөгийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд хөнгөлөлттэй хүүтэй байршуулсантай холбоотой байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 45,781.0 сая төгрөгөөр буурсан нь ажилгүйдлийн даатгалын сангийн үлдэгдэл 20,256.4 сая, ҮОМШӨ-ний даатгалын сангийн үлдэгдэл 17,436.7 сая, тэтгэврийн даатгалын сангийн үлдэгдэл 7,646.6 сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт №2. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, төрлөөр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилгүйдлийн даатгалын сан	101,471.1	42,614.6	-58,856.5
Тэтгэврийн даатгалын сан	381,121.2	249,115.2	-132,006.0
Тэтгэмжийн даатгалын сан	61,025.1	40,662.7	-20,362.4
ҮОМШӨ-ний даатгалын сан	707,808.6	380,753.7	-327,054.9
Эрүүл мэндийн даатгалын сан	7,776.3	9,467.7	1,691.4
Төвлөрсөн харилцах данс	2,807.7	9,336.3	6,528.6
Үйл ажиллагааны харилцах данс	576.2	363.4	-212.8
Замд яваа мөнгө	-	59.6	59.6
Дүн	1,262,586.2	732,373.2	-530,213.0

Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн 380,753.7 сая төгрөг ҮОМШӨ-ний даатгалын сангийн, 249,115.2 сая төгрөг тэтгэврийн даатгалын сангийн, 42,614.6 сая төгрөг ажилгүйдлийн даатгалын сангийн, 40,662.7 сая төгрөг тэтгэмжийн даатгалын сангийн, 19,227.0 сая төгрөг бусад мөнгө эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Нийгмийн даатгалын төвлөрсөн орлогын арилжааны банкууд дахь нийт 2,240.9 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангуудад хуваарилаагүй /Сүхбаатар дүүрэг 1,966.8 сая, Өмнөговь 259.0, Булган 9.9 сая, Сэлэнгэ 5.1 сая/;

- Анхан шатны баримт бүрдэл хангалтгүй, төлбөрийн и-баримтгүй худалдан авалт хийсэн /Баянгол 103.9 сая, НДЕГ 74.4 сая, Говь-Алтай 34.7 сая, Булган 18.8 сая, Хан-Уул дүүрэг 10.9 сая/

3.5.2 Авлага

Авлагын дансны эхний үлдэгдэл 251,411.2 сая, эцсийн үлдэгдэл 1,436,859.3 сая төгрөг болж, 1,185,448.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Авлагын дансны үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төлбөртэй үйлчилгээний авлага	138,273.0	197,168.7	58,895.7
Татаас, санхүүжилтийн авлага	-	691,612.9	691,612.9
Байгууллагаас авах авлага	113,071.9	547,991.7	434,919.8
Хувь хүмүүсээс авах авлага	66.3	86.0	19.7
Дүн	251,411.2	1,436,859.3	1,185,448.1

Авлагын дансны үлдэгдлийн 691,612.9 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлага, 547,991.7 сая төгрөгийг байгууллагаас авах авлага, 197,168.7 сая төгрөгийг төлбөртэй үйлчилгээний авлага, 86.0 сая төгрөгийг хувь хүмүүсээс авах авлага эзэлж байна.

Тайлант онд албан журмын даатгуулагчийн 619,055.9 сая, сайн дурын даатгуулагчийн 23,533.5 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлтүүд болон ажилгүйдлийн дэмжлэгийн 39,880.5 сая, зарим иргэдийн тэтгэврийн зөрүү 9,143.0 сая нийт 691,612.9 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Байгууллагаас авах авлага 434,919.8 сая төгрөгөөр буюу 4.8 дахин өссөн нь ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын санд 435,416.0 сая төгрөгийг шилжүүлэн¹ зарцуулсныг сан хооронд авлага үүсгэн бүртгэсэнтэй холбоотой байна.

Төлбөртэй үйлчилгээний авлага 58,895.7 сая төгрөгөөр өссөн нь Коронавируст халдварт цар тахлын улмаас хөл хорио тогтоож, аж ахуйн нэгж байгууллагуудыг алданги торгуулиас чөлөөлсөн, мөн нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг барагдуулаагүйгээс шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй 124.0 сая төгрөг /Хэнтий 82.5 сая, Чингэлтэй дүүрэг 41.5 сая/;
- Тайлант онд авлага барагдуулаагүй, насжилт өндөртэй, хэвийн бус авлага 514.4 сая төгрөг /Өмнөговь 270.1 сая, Дорнод 103.0 сая, Булган 90.5 сая, Сүхбаатар дүүрэг 50.8 сая/ байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 952.4 сая, эцсийн үлдэгдэл 1,159.9 сая төгрөг болж, 207.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Бараа материалын дансны үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бэлэн бүтээгдэхүүн	101.9	96.0	-5.9
Хангамжийн бараа материал	850.5	1,063.9	213.4
Дүн	952.4	1,159.9	207.5

Бараа материалын дансны 1,063.9 сая төгрөгийг хангамжийн материал, 96.0 сая төгрөгийг бэлэн бүтээгдэхүүн эзэлж байна.

Бэлэн бүтээгдэхүүнд нийгмийн даатгалын шимтгэлийн өрөнд авсан барааны үлдэгдлийг тайлагнасан бөгөөд хангамжийн материалд байгууллагын албан хэрэгцээнд ашиглах бичиг

¹ Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх хуулийн 4 дүгээр зүйл "... Нийгмийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 2, 4, 5 дахь хэсэгт заасан сан хооронд хөрөнгө шилжүүлэн зарцуулж болно."

хэрэг, аж ахуй, сэлбэг, түлш шатахуун, анхан шатны маягтыг бүртгэсэн байна. Тайлант онд бараа материалын дансанд материаллаг өөрчлөлт гараагүй байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 35,598.9 сая, эцсийн үлдэгдэл 38,657.5 сая төгрөг болж, 3,058.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Үндсэн хөрөнгө			
Биет хөрөнгө	34,074.3	33,887.8	-186.5
Биет бус хөрөнгө	1,524.6	4,769.7	3,245.1
Дүн	35,598.9	38,657.5	3,058.6

Тайлант онд 6.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвөөс бэлтгэж, 4,893.6 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст, 1,018.6 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар, дахин үнэлгээний нэмэгдэл 6.4 сая төгрөг нийт 5,924.7 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, балансаас баланст 25.0 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, 1,449.1 сая төгрөгийн хөрөнгийг акталж устган 1,454.5 сая төгрөгийн элэгдлийн зардлыг хасаж, 2,846.5 сая төгрөгийн элэгдлийг байгуулсан байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эхний үлдэгдэл 21,007.9 сая, эцсийн үлдэгдэл 462,428.5 сая төгрөг болж, 441,420.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Өр төлбөрийн дансны үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр			
Өглөг	5,088.4	441,627.9	436,539.5
Бусад өглөг	7,792.5	9,487.0	1,694.5
Урьдчилж орсон орлого	8,127.0	11,313.6	3,186.6
Дүн	21,007.9	462,428.5	441,420.6

Өглөгийн данс 441,420.6 сая төгрөгөөр өссөн нь тэтгэврийн даатгалын санд ҮОМШӨ-ний даатгалын сангаас 435,416.0 сая төгрөгийг шилжүүлэн зарцуулж, сан хооронд өглөг үүсгэсэн нь голлон нөлөөлжээ.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 1,529,563.6 сая, эцсийн үлдэгдэл 1,746,643.1 сая төгрөг болж, өмнөх оноос 217,079.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Өр төлбөр дансны үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын хувь оролцоо	1,529,563.6	1,746,643.1	217,079.5
Дүн	1,529,563.6	1,746,643.1	217,079.5

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн 216,733.0 сая төгрөгөөр өссөнөөс голлон нөлөөлсөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Төсвийн захирагч нь 2020 оны төсвийн төслийг боловсруулахдаа нийт орлогыг 2,632,400.0 сая, нийт зарлагыг 2,472,400.0² сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуулиар нийт орлогыг 2,692,369.8 сая, нийт зарлагыг 2,494,043.3 сая төгрөгөөр баталсан байна.

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр³ нийт орлогыг 880,111.1 сая төгрөгөөр бууруулж, 1,812,258.7 сая төгрөгөөр баталжээ. Үүнд аж ахуйн нэгж байгууллагаас төлөх шимтгэлийг 324,268.4 сая, ажиллагчдаас төлөх шимтгэлийг 209,920.5 сая, сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэлийг 149,481.1 сая, бусад орлогыг 198,578.9 сая төгрөгөөр бууруулж, төсөвт байгууллагаас төлөх шимтгэлийг 2,137.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн өөрчилсөн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд нийгмийн даатгалын сангийн зардалд нийт 2,494,043.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,466,834.3 сая төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, ҮОМШӨ-ний болон ажилгүйдлийн даатгалын сангуудад, 27,209.0 сая төгрөгийг үйл ажиллагааны урсгал зардалд зарцуулахаар төлөвлөжээ.

Нийгмийн даатгалын сангийн нийт орлогын 1,361,426.0 сая төгрөгийг шимтгэлийн орлогоос, 399,417.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 50,315.1 сая төгрөгийг бусад эх үүсвэрээс, 1,100.0 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх нийт орлогыг 1,812,258.7 сая төгрөгөөр баталснаас 1,878,187.3 сая төгрөг буюу 103.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №8. Нийгмийн даатгалын сангийн нийт орлого /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэврийн даатгалын сан	1,557,944.5	1,595,369.8	-37,425.3	102.4
Тэтгэмжийн даатгалын сан	97,882.8	111,393.9	-13,511.1	113.8
ҮОМШӨ-ний даатгалын сан	130,777.3	145,482.4	-14,705.1	111.2
Ажилгүйдлийн даатгалын сан	25,654.1	25,941.2	-287.0	101.1
Дүн	1,812,258.7	1,878,187.3	-65,928.6	103.6

Нийгмийн даатгалын сангийн орлого 65,928.6 сая төгрөгөөр давж биелсэн нь нийгмийн даатгалд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын тоо өмнөх оноос 1.1 мянгаар өссөн нь нөлөөлсөн байна.

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг алданги, торгуулийн орлого, туслах үйл ажиллагааны орлогыг иргэдэд үйлчилсний орлого, түрээсийн орлогоос бүрдүүлж байна.

Тайлант онд 170.0 сая төгрөгийн туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө батлагдсанаас үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,377.0 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 302.0 сая нийт 1,679.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 9.9 дахин давуулан биелүүлсэн байна.

Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага 2,494,043.3 сая төгрөгөөр батлагдсанаас 2,451,795.9 сая төгрөг буюу 98.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №9. Нийгмийн даатгалын сангийн нийт зарлага /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэврийн даатгалын сан	2,172,968.7	2,153,553.8	19,414.9	99.1
Тэтгэмжийн даатгалын сан	143,758.6	145,409.7	-1,651.1	101.1
ҮОМШӨ-ний даатгалын сан	35,042.1	31,649.6	3,392.5	90.3
Ажилгүйдлийн даатгалын сан	115,064.9	94,388.5	20,676.4	82.0
Үйл ажиллагааны урсгал зардал	27,209.0	26,794.3	414.7	98.5
Дүн	2,494,043.3	2,451,795.9	42,247.4	98.3

² Тэтгэвэр бодох итгэлцүүрийг хэвээр мөрдөх тохиолдолд (итгэлцүүр шинэчлэх тохиолдолд 2,925,500.0 сая төгрөгөөр)

³ Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.

Тайлант онд тэтгэврийн даатгалын сан 99.1 хувийн, тэтгэмжийн даатгалын сан 101.1 хувийн, ҮОМШӨ-ний даатгалын сан 90.3 хувийн, ажилгүйдлийн даатгалын сан 82.0 хувийн, үйл ажиллагааны урсгал зардал 98.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тэтгэмжийн даатгалын сан 1,651.1 сая төгрөгөөр хэтэрсэн нь 2020 оноос сайн дурын даатгуулагчдын жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг 100.0 хувиар тооцон олгохтой холбоотойгоор тэтгэмжийн хэмжээ өссөн байна.

Үйл ажиллагааны зардал 27,209.0 сая төгрөгөөр батлагдсанаас 26,794.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа нь орон тооны хэмнэлт гарснаас үндсэн цалинг 164.5 сая, коронавируст халдварт цар тахалтай холбоотойгоор нэг удаагийн шинжтэй тэвчиж болох хангамж бараа материал, томилолт, эд хогшил, урсгал засвар, хичээл үйлдвэрлэлийн зэрэг зардлуудыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд хандив тусламжаар 71,099.3 сая /Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих төслөөс 42,632.4 сая, Онцгой байдлын үеийн хөдөлмөр эрхлэлтийн төсөл 28,450.0, бусад 16.9 сая/, ЗДНХ болон дээд шатны төсөв захирагчаас 295.8 сая, нийт 71,395.1 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтээр авсан байна.

Үүнээс албан журмын болон сайн дурын даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэл чөлөөлөлтөд 71,032.4 сая, хангамжийн материалын зардалд 114.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 79.4 сая, бусад зардалд 145.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны тэнцлийг 681,784.5 сая төгрөгийн алдагдалтай төлөвлөснөөс гүйцэтгэлээр 108,175.8 сая төгрөгөөр буурч, 573,608.7 сая төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Хүснэгт №10. Нийгмийн даатгалын сангийн тэнцэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэврийн даатгалын сан	Орлого	1,557,944.5	1,595,369.8	-37,425.3	102.4
	Зарлага	2,194,662.5	2,174,916.9	19,745.6	99.1
	Тэнцэл	-636,718.0	-579,547.1	-57,170.9	91.0
Тэтгэмжийн даатгалын сан	Орлого	97,882.8	111,393.9	-13,511.1	113.8
	Зарлага	146,126.2	147,740.8	-1,614.6	101.1
	Тэнцэл	-48,243.4	-36,346.9	-11,896.5	75.3
ҮОМШӨ-ний даатгалын сан	Орлого	130,777.3	145,482.4	-14,705.1	111.2
	Зарлага	37,660.4	34,227.2	3,433.2	90.9
	Тэнцэл	93,116.9	111,255.2	-18,138.3	119.5
Ажилгүйдлийн даатгалын сан	Орлого	25,654.1	25,941.1	-287.0	101.1
	Зарлага	115,594.1	94,911.0	20,683.1	82.1
	Тэнцэл	-89,940.0	-68,969.9	-20,970.1	76.7
Дүн	Орлого	1,812,258.7	1,878,187.2	-65,928.5	103.6
	Зарлага	2,494,043.2	2,451,795.9	42,247.3	98.3
	Тэнцэл	-681,784.5	-573,608.7	-108,175.8	84.1

Тайлант онд нийт 1,146.5 мянган даатгуулагч, үүнээс албан журмын даатгалд 953.4 мянга, сайн дурын даатгалд 193.1 даатгуулагч хамрагджээ. Нийгмийн даатгалын сангаас

441.4 мянган иргэн тэтгэврийн, 215.8 мянган иргэн төлбөр, тэтгэмжийн үйлчилгээ хүлээн авсан байна.

Дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдварт цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаа нь аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, ашиглагдаж байгаа программ хангамж, мэдээлэлтэй биечлэн танилцах, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлж анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулах боломжгүй байсан, цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөлд аудитыг хийж гүйцэтгэв.

3.8 Аудитын гол асуудал

Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль, Засгийн газрын 2020 оны 140 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ын дагуу 38.4 мянган ажил олгогчдын 410.6 мянган албан журмын даатгуулагчийн 647,505.9 сая, 169.2 мянган сайн дурын даатгуулагчийн 66,166.8 сая нийт 713,672.7 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг чөлөөлж, 7.3 мянган ажил олгогчийн 220.7 мянган⁴ даатгуулагчид 44,148.0 сая төгрөгийн ажилгүйдлийн дэмжлэгийг олгосон байна.

Тайлант онд НДЕГ нь Сүхбаатар дүүргийн шүүхэд Чингис хаан банканд холбогдуулан нийгмийн даатгалын сангийн нийт 101,768.2 сая төгрөгийг гаргуулах тухай нэхэмжлэлийг гаргажээ. Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 181/ШШ/2020/02624 дүгээр захирамжаар Чингис хаан банк нь нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон байна. НДЕГ нь Чингис хаан банкттай 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 11/05 дугаар “Төлбөр барагдуулах гэрээ” байгуулсан боловч гэрээнд заасан хуваарийн дагуу төлбөрийг барагдуулаагүй байна.

Мөн нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө байршиж байгаа Үндэсний хөрөнгө оруулалтын банкттай 2020 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн СБГ-2 дугаар “Харилцах, хадгаламжийн данснаас зарлагын гүйлгээ хийх гэрээ” байгуулсан боловч гэрээний хэрэгжилт хангалтгүй, хуваарийн дагуу төлөх төлбөрүүдийг төлөөгүй байна.

3.9 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд НДЕГ-ын харьяа 26 байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд 10,057 мэдээлэл байршуулахаас 379 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 133 мэдээллийг байршуулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 111,561.8 сая төгрөгийн 6 зөрчил илрүүлснээс 100,949.4 сая төгрөгийн 2 албан шаардлага, 10,612.4 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Хүснэгт №11. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	2	100,949.4	1	5.6	50.0
Зөвлөмж	4	10,612.4	3	10,612.4	75.0
Нийт дүн	6	111,561.8	4	10,618.0	62.5

⁴ Давхардсан тоогоор

Өмнөх аудитаар өгсөн 1 албан шаардлага, 3 зөвлөмжийг хэрэгжүүлж, нэр бүхий 2 банканд байршиж байгаа мөнгөн хөрөнгийн эрсдэлийг бууруулж, татан төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллах талаар өгсөн албан шаардлага хэрэгжээгүй, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын цогц программыг шинэчилж, ашиглах талаар өгсөн зөвлөмж хэрэгжих шатандаа байна.

3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлангийн дараах үйл явдал

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн “Өр барагдуулах тухай” 02 дугаар тогтоолоор дампуурсан Капитал банк дахь эрх хүлээн авагчаас 67,430.6 сая төгрөгийн 98 ширхэг үл хөдлөх хөрөнгийг нийгмийн даатгалын сангийн нэхэмжилсэн өр төлбөрт суутган авахаар тогтоожээ.

Мөн Чингис хаан банк нь Сүхбаатар дүүргийн шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 181/ШШ2020/02624 дугаар захирамжийн дагуу харилцах дансны 2020 оны 8,9,10 сарын хуримтлагдсан хүү 2,619.3 сая төгрөгийг буцаан татсан байна.

НДЕГ нь Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 1/131 дугаар албан бичгээр Чингис хаан банкныг шүүхийн захирамжийг гүйцэтгүүлэх тухай хүсэлт, 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 1/529 дугаар албан бичгээр Үндэсний хөрөнгө оруулалтын банкнаас нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг гаргуулах тухай нэхэмжлэл гаргажээ.

Дээрх банкуудад холбогдох нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн асуудлыг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай байна.

Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймаг, дүүргийн НДХ-үүдийн үйл ажиллагааны санхүүжилтийн үлдэгдэл 421.7 сая, цэргийн байгууллагуудаас орж ирсэн шинээр тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчийн үйлчилгээний зардал, банкаар тэтгэвэр олгосон үйлчилгээний шимтгэлийн төлбөр 23.6 сая төгрөгийг өмнөх үеийн үр дүнд бүртгэжээ.

Нийгмийн даатгалын сангийн зарцуулагдаагүй үлдэгдлийг өмнөх үеийн үр дүнд бүртгэсэн асуудлуудыг Засгийн газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 35 санхүүгийн тайлан нэгтгэгдэж аудитад хамрагдсанаас Зөрчилгүй 30, Хязгаарлалттай 1 дүгнэлт авч, итгэл үзүүлсэн 1, түүвэрт хамрагдсан 3 тайлан байна.

4.1 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Нийгмийн даатгалын сангийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 2,391.0 сая төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй нийт 6,250.1 сая төгрөгийн 111 алдаа, зөрчил илрүүлснээс 13.8 сая төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт тогтоож, 844.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 32 албан шаардлага хүргүүлж, 5,391.8 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 71 зөвлөмж өгсөн байна.

НДЕГ-ын 2020 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитаар “Хязгаарлалттай” дүгнэлтийг өгсөн. Аудитаар нийт 485.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс, 20.4 сая төгрөгийн алдааг залруулж, 13.4 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 451.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өгсөн.

4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 26,770.9 сая төгрөгийн 8 алдаа зөрчил илрүүлснээс 17,627.8 сая төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 9,143.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Албан шаардлага

1. Тайлант онд авлага, өглөгийн данстай холбоотой нийт 10,781.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- a. Байгууллага, хувь хүнээс авах 6,455.5 сая төгрөгийн авлага, 59.1 сая төгрөгийн өглөг, улсын төсвийн санхүүжилт 4,267.5 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, иргэд байгууллагуудын 1999 оноос хойш хуримтлагдсан, олон жилийн насжилттай авлага, өглөгийг шийдвэрлээгүй;
- b. Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлт 642,589.4 сая, даатгуулагчдад ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон дэмжлэг 39,880.5 сая нийт 682,469.9 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах, барагдуулах, татаас санхүүжилтийн авлагатай холбоотой асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар албан шаардлага хүргүүлэв.

2. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө байршиж байгаа Чингис хаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банкттай холбоотой нийт 6,750.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Банкууд төлбөр барагдуулах, харилцах, хадгаламжийн данснаас зарлагын гүйлгээ хийх гэрээнд заасан хуваарийн дагуу төлөлтүүдийг хийгээгүй; /Чингис хаан банк 2,000.0 сая, Үндэсний хөрөнгө оруулалтын банк 4,750.0 сая төгрөг/
- Мөнгөн хадгаламжийн гэрээнд заасны дагуу сар бүр Монголбанкнаас хянаж, тогтоосон банкны зохистой харьцааны үзүүлэлтийн мэдээг ирүүлээгүй байгаа зөрчлүүд нь нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө алдагдах, төлөгдөхгүй байх эрсдэлтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Банкуудтай байгуулсан гэрээний үүргийг хангуулж ажиллах, Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг хадгаламж хэлбэрээр байршуулахад холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

3. Нийгмийн даатгалын төв сангийн санхүүгийн тайланд Сүхбаатар дүүргийн шүүхийн 2010 оны 1615 дугаар шийдвэрээр нийгмийн даатгалын шимтгэлийн өрөнд хүлээн авсан 96.0 сая төгрөгийн үнэ бүхий 121 м.кв талбайтай үйлчилгээний зориулалттай подвал бүртгэлтэй байна. Тус подвалын үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг тухайн хуулийн этгээдээс шилжүүлэн аваагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын өрөнд авсан эд хөрөнгийг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх, авлагыг бүрэн барагдуулж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

4. НДЕГ-ын харьяа 26 байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд 94,843.2 сая төгрөгийн 379 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 66,631.9 сая төгрөгийн 133 мэдээллийг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хуулиар тогтоосон хугацаанд бүрэн байршуулж байх талаар албан шаардлага хүргүүлэв.

5. НДЕГ нь төв сан, төв сангийн үйл ажиллагаа, маягтын зарцуулалтын санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад хүргүүлээгүй, Нийгмийн даатгалын сангийн 2020 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангаа хуулиар тогтоосон хугацаанд иж бүрэн бэлтгэж төрийн аудитын байгууллагад хүргүүлэх талаар албан шаардлага хүргүүлэв.

НДЕГ-ын харьяа 3 байгууллагыг аудитын түүвэрт хамруулсан. Аудитаар НДЕГ-ын дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн нэр бүхий 9 албан хаагчдад мөнгөн урамшууллыг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгоогүй зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн оруулав. Үүнд:

1.Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын сан нь дампуурсан Капитал банкнаас 103,380.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Тайлант хугацаанд банкны эрх хүлээн авагчаас тус банканд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгүүд болон зээлийн төлбөрт тооцон авсан хөрөнгөөс өмчлөх эрхийг шилжүүлэх замаар өр төлбөрийг барагдуулах талаар саналыг ирүүлсэн байна.

Өр төлбөрт суутган авах үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой худалдан борлуулах, хадгалж хамгаалах зэрэг тооцоолоогүй зардлууд гарах, хөрөнгө борлогдохгүй удсанаар чанар байдал муудах, үнэлгээ буурах, авлага бүрэн барагдахгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.*”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 6.4.8-д “*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2-т “*нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах*” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг эрсдэлээс хамгаалж, өр төлбөрийг суутган шилжүүлэх хөрөнгийн үнэлгээ нэхэмжлэлийн шаардлагын хэмжээнд бүрэн нийцэхгүй байгаа тохиолдолд холбогдох арга хэмжээг авах, авлагыг бүрэн барагдуулж ажиллах.

2. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд Нийгмийн даатгалын 2020 оны төсвийн тухай хуулиар батлагдсан улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 9,143.0 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж, татаас санхүүжилтийн авлагыг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн 3 дугаар зүйлд “... аж ахуйн нэгжийн даатгуулагч Монгол Улсын иргэнд ... хугацаанд ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200.0 /хоёр зуун/ мянган төгрөгийн дэмжлэг олгоно.” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг бодитой тооцоо судалгаанд үндэслэн тооцож, дээд шатныхаа төсвийн захирагчид хүргүүлж, батлуулах, татаас санхүүжилтийн авлага үүсгэхгүй байх, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах.

3. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант онд Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Монголбанк, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс тухайн жилд арилжааны банканд хадгаламж хэлбэрээр байршуулах нийт хөрөнгийн хэмжээг тогтоогоогүй бөгөөд Тээвэр хөгжлийн банканд 10,000.0 сая төгрөгийн мөнгөн хадгаламжийг хугацаа сунган байршуулсан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5-д “Хуримтлалын сангаас арилжааны банканд байршуулах хөрөнгийн хэмжээг санхүүгийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанк, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл хамтран тогтооно.” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 08 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг арилжааны банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах журам”-ын 3.4-т “Нийгмийн даатгалын ерөнхий газар нь ... хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн тухайн жилийн дээд хэмжээг тооцоолон, эхний улиралд багтаан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэх” гэж заасныг баримтлаагүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, тохиолдсон байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын сангийн тухайн жилд банканд хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн хэмжээг тооцоолон, хэлэлцүүлж, батлуулах, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Харьяа байгууллагууд	Дүгнэлтийн хэлбэр				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ										
1	Нийгмийн даатгалын сан	1						5	17,627.8	3	9,143.1
	ДҮН	1						5	17,627.8	3	9,143.1
	ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ										
1	НДЕГ		1					4	13.4	7	451.5
2	НДЕГ-ын дэргэдэх Мэдээллийн технологийн төв							1	-		
3	Нийслэлийн нийгмийн даатгалын газар	1				1	0.2	2	4.5	4	3.4
4	Багануур дүүргийн НДС	1								5	31.8
5	Багахангай дүүргийн НДС	1						2	2.4	3	1.8
6	Баянгол дүүргийн НДС	1						4	103.7	3	166.9
7	Баянзүрх дүүргийн НДС	1				1	1.8	1	0.0	6	430.0
8	Налайх дүүргийн НДС	1				1	8.0			2	42.6
9	Сонгинохайрхан дүүргийн НДС	1						1	0.0	4	139.2
10	Сүхбаатар дүүргийн НДС	1						1	0.0	4	2,271.7
11	Хан-Уул дүүргийн НДС	1								4	62.7
12	Чингэлтэй дүүргийн НДС	1						1	41.5	1	7.0
13	Архангай аймгийн НДС	1				1	1.0			1	12.7
14	Баян-Өлгий аймгийн НДС	1								1	686.5
15	Баянхонгор аймгийн НДС	1				1	1.7			2	5.6
16	Булган аймгийн НДС	1				2	0.9	5	47.0	4	267.1
17	Говь-Алтай аймгийн НДС	1				1	0.1	2	1.0	1	34.7
18	Говьсүмбэр аймгийн НДС	1						2	0.0	2	4.5
19	Дархан-Уул аймгийн НДС	1								1	0.0
20	Дорноговь аймгийн НДС	1						1	1.5		
21	Дорнод аймгийн НДС	1						1	103.0		
22	Дундговь аймгийн НДС	1									
23	Завхан аймгийн НДС	1									
24	Орхон аймгийн НДС	1						1	4.4	3	23.8
25	Өвөрхангай аймгийн НДС	1									
26	Өмнөговь аймгийн НДС	1								5	739.1
27	Сэлэнгэ аймгийн НДС	1						1	17.9	3	7.9
28	Төв аймгийн НДС	1						1	399.5		
29	Увс аймгийн НДС	1									
30	Ховд аймгийн НДС	1									
31	Хөвсгөл аймгийн НДС	1								5	1.2
32	Хэнтий аймгийн НДС	1						1	104.7		
	ДҮН	30	1			8	13.8	32	844.5	71	5,391.8
	НИЙТ ДҮН	31	1			8	13.8	37	18,472.3	74	14,534.9

6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР				
1	Автомашин зарцуулах нормоос 112.3 литр буюу 222.3 мянган төгрөгийн шатахууныг хэтрүүлэн зарцуулсан.	0.2	Төлбөрийн акт	Захирал, нягтлан бодогч	Г.Болорсүх, М.Цандмаа
	БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НДС				
2	Төрийн өмчийн байрыг түрээслэн олсон орлогын 40 хувийг төсөвт төвлөрүүлээгүй.	1.8	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Ш.Ариунтуяа, Ц.Наранмандах
	НАЛАЙХ ДҮҮРГИЙН НДС				
3	2020 оны үр дүнгийн урамшууллыг оны эцэст 60 хувиар илүү давхардуулж олгосон.	8.0	Төлбөрийн акт	Дарга	Ч.Өнөржаргал
	АРХАНГАЙ АЙМГИЙН НДС				
4	Сахилгын шийтгэлтэй албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгосон.	1.0	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	А.Ариунтуяа, Ц.Булганчимэг
	БАЯНХОНГОР АЙМГИЙН НДС				
5	Дулаан үйлдвэрлэгчид дулааны төлбөрийг илүү шилжүүлсэн.	1.7	Төлбөрийн акт	Хэлтсийн дарга, нягтлан бодогч	Д.Мөнхбат, С.Хонгорзул
	БУЛГАН				
6	Нэр бүхий албан хаагчдад томилолтоор ажиллах хугацаанд хоолны мөнгө давхардуулан олгосон.	0.2	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Ц.Энх-Амгалан, Д.Амгалан
7	Өмнөх оны өглөгт бүртгээгүйгээр цалингийн зардлаас даргад үр дүнгийн урамшуулал олгосон, үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон.	0.8	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	Ц.Энх-Амгалан, Д.Амгалан
	ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НДС				
8	Ажлаас чөлөөлөгдсөн даатгуулагчид 110.1 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг илүү тооцож олгосон.	0.1	Төлбөрийн акт	Дарга, СБХОБ-ийн тасгийн дарга, нягтлан бодогч, Тэтгэмжийн байцаагч	Л.Энхжаргал, Х.Аюуш, Н.Янжиндолгор, Б.Дамчийбадгар
	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН				
9	Тайлант онд авлага, өглөгийн данстай холбоотой нийт 10,781.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд: - Байгууллага, хувь хүнээс авах 6,455.5 сая төгрөгийн авлага, 59.1 сая төгрөгийн өглөг, улсын төсвийн санхүүжилт 4,267.5 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, иргэд байгууллагуудын 1999 оноос хойш хуримтлагдсан, олон жилийн насжилттай авлага, өглөгийг шийдвэрлээгүй;	10,781.8	Албан шаардлага	НДЕГ-ын дарга, Санхүү бүртгэлийн газрын дарга, Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга	Д.Зоригт, Б.Даваахүү, Ц.Ганцэцэг

**Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	- Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлт 642,589.4 сая, даатгуулагчдад ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон дэмжлэг 39,880.5 сая нийт 682,469.9 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн.				
10	Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө байршиж байгаа Чингис хаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банктэй холбоотой нийт 6,750.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд: - Банкууд төлбөр барагдуулах, харилцах, хадгаламжийн данснаас зарлагын гүйлгээ хийх гэрээнд заасан хуваарийн дагуу төлөлтүүдийг хийгээгүй; /Чингис хаан банк 2,000.0 сая, Үндэсний хөрөнгө оруулалтын банк 4,750.0 сая төгрөг/ - Мөнгөн хадгаламжийн гэрээнд заасны дагуу сар бүр Монголбанкнаас хянаж, тогтоосон банкны зохистой харьцааны үзүүлэлтийн мэдээг ирүүлээгүй байгаа зөрчлүүд нь нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө алдагдах, төлөгдөхгүй байх эрсдэлтэй байна.	6,750.0	Албан шаардлага	НДЕГ-ын дарга, Санхүү бүртгэлийн газрын дарга	Д.Зоригт, Б.Даваахүү
11	Сүхбаатар дүүргийн шүүхийн 2010 оны 1615 дугаар шийдвэрээр нийгмийн даатгалын шимтгэлийн өрөнд хүлээн авсан 96.0 сая төгрөгийн үнэ бүхий 121 м.кв талбай бүхий үйлчилгээний зориулалттай подвалыг шилжүүлж аваагүй.	96.0	Албан шаардлага	НДЕГ-ын дарга, Санхүү бүртгэлийн газрын дарга	Д.Зоригт, Б.Даваахүү
12	НДЕГ-ын харьяа 26 байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд 94,843.2 сая төгрөгийн 379 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 66,631.9 сая төгрөгийн 133 мэдээллийг байршуулаагүй.	-	Албан шаардлага	НДЕГ-ын дарга, Дотоод аудит мониторингийн газрын дарга	Д.Зоригт, Б.Ганхуяг
13	НДЕГ нь төв сан, төв сангийн үйл ажиллагаа, маягтын зарцуулалтын санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад хүргүүлээгүй, Нийгмийн даатгалын сангийн 2020 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй.	-	Албан шаардлага	НДЕГ-ын дарга, Санхүү бүртгэлийн газрын дарга	Д.Зоригт, Б.Даваахүү
НДЕГ					
14	Хөлсөөр ажиллуулж байгаа 17 ажилтанд үр дүнгийн урамшууллыг 80 хувиар тооцон 10,600.5 мянган төгрөг, 5 ажилтанд төрийн алба хаасан	13.4	Албан шаардлага	Тамгын газрын дарга	Б.Батсүх

**Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	хугацааны нэмэгдлийг үндсэн цалингийн 5-20 хувиар тооцон 2,758.4 мянган төгрөгийг тус тус олгосон.				
15	Шилэн дансны цахим хуудсанд нийт 82 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	-	Албан шаардлага	Дотоод аудит мониторинг	Б.Ганхуяг
16	НДЕГ-ын санхүүгийн бүртгэлд 2006 оноос ашиглаж байгаа "Sanhuu" программ хангамж нь нягтлан бодох бүртгэл хөтлөх программ хангамжийн зөвшөөрлийг аваагүй, холбогдох хууль тогтоомж болон Сангийн сайдын баталсан заавар журмын дагуу тайлан мэдээ бэлтгэн боловсруулдаггүй.	-	Албан шаардлага	Мэдээлэл технологийн төвийн дарга	Г.Хүрэлбаатар
17	НДЕГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3 гражийн газрыг Баянгол дүүргийн засаг даргын захирамжаар 2014 онд хуулийн этгээд, иргэнд эзэмшүүлсэн байна. Тус гражийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт акталж данснаас хасах саналыг хүргүүлсэн.	-	Албан шаардлага	НДЕГ-ын өмч хамгаалах комиссын дарга	Г.Саран
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ДЭРГЭДЭХ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВ					
18	Нэр бүхий 9 албан хаагч тус бүрд тухайн жилийн мөнгөн урамшууллыг нийт 190 - 810 хувиар илүү тооцож олгосон.	-	Албан шаардлага	Захирал, нягтлан бодогч	Г.Хүрэлбаатар, Ц.Нармандах
НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР					
19	Автомашинуудын 364.4 мянган төгрөгийн татвар, төлбөрийг төлөөгүй, замын хөдөлгөөний дүрмийг зөрчин 1,237.4 мянган төгрөгийн торгууль ногдуулсан.	1.6	Албан шаардлага	Захирал, нягтлан бодогч, жолооч	Г.Болорсүх, М.Цандмаа, Хуяг
20	2020 оны эхний хагас жилд албан хэрэгцээнд 4700м3 багтаамжтай автомашиныг хэрэглэж 2,897.4 мянган төгрөгийн шатахууны зардлыг гаргасан.	2.9	Албан шаардлага	Захирал, нягтлан бодогч	Г.Болорсүх, М.Цэндмаа
БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НДС					
21	Төрийн албанаас тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг 1,041.0 мянган төгрөгөөр зөрүүтэй бодож олгосон.	1.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	И.Батнасан, Б.Удвал
22	Ахмадын сангаас ажилтнуудад 1,369.5 мянган төгрөгийн урамшуулал олгосон.	1.4	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	И.Батнасан, Б.Удвал
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НДС					
23	Батлагдсан орон тоог 9-өөр хэтрүүлэн ажиллаж цалин, нэмэгдэлд 92,195.7 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 11,524.5 мянган төгрөгийг зарцуулсан.	103.7	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Б.Ууган-Эрдэнэ, Ч.Батзаяа
24	Хэлтсийн байранд 2 иргэнтэй түрээсийн гэрээг төлбөргүй байгуулж нийт 15.8 м2 талбайг үнэ төлбөргүй түрээслүүлсэн.	-	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Б.Ууган-Эрдэнэ, Ч.Батзаяа
25	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй.	-	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Б.Ууган-Эрдэнэ, Ч.Батзаяа

**Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

26	Санхүүгийн программууд нь гар ажиллагаа их шаардсан, бусад байгууллагуудын программ хангамжтай харилцан уялдаагүй, ерөнхий журнал, ерөнхий дэвтрийг гүйлгээ бүрээр боловсруулах боломжгүй, санхүүгийн тайлан, тодруулгуудыг батлагдсан маягт аргачлалаар шинэчилж өөрчлөөгүй.	-	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Б.Ууган-Эрдэнэ, Ч.Батзаяа
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НДС					
27	Шилэн дансны цахим хуудсанд сангийн орлогын 3 гүйлгээ дутуу, зарлага 69 гүйлгээ үйл ажиллагааны орлогын 7 гүйлгээ, зарлагын 4 гүйлгээ, худалдан авалтын 3 мэдээллийг тус тус дутуу байршуулсан, батлагдсан төсвийг 51,150.0 мянган төгрөгөөр илүү оруулсан.	-	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ш.Ариунтуяа, Ц.Наранмандах
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НДС					
28	Шилэн дансны цахим хуудсанд өмч хөрөнгө, өглөг, авлагатай холбоотой 14 мэдээллийг байршуулаагүй, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	0.0	Албан шаардлага		
СҮХБААТАР ДҮҮРГИЙН НДС					
29	Шилэн дансны цахим хуудсанд 25 мэдээллийг хугацаа хожимдуулж байршуулсан.	0.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Б.Алтангэрэл, Б.Бадамсэрээжид
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НДС					
30	Бусад авлага дансанд хөдөлгөөнгүй, насжилт өндөртэй хувь хүнээс авах нийт 41,451.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй.	41.5	Албан шаардлага	Дарга, ерөнхий нягтлан бодогч	Н.Ариунаа, М.Энхмаа
БУЛГАН АЙМГИЙН НДС					
31	Нийгмийн даатгалын сангийн төрийн болон Хаан банкны төвлөрсөн орлогын харилцах дансны орлогын үлдэгдлийг сангуудад хуваарилаагүй.	9.9	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ц.Энх-Амгалан, Д.Амгалан
32	Бараа материалын тайлангаас зарцуулалт хийхдээ анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй.	30.3	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ц.Энх-Амгалан, Д.Амгалан
33	Сумдын байцаагч нарт олгох батлагдсан тээвэр шатахууны зардлыг сар бүр олголгүй, хэлтсийн албаны хэрэгцээнд хэтрүүлэн зарцуулсан.	4.3	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ц.Энх-Амгалан, Д.Амгалан
34	НДЕГ-аас тайлан тушаахад хуваарьт албан бичиг байхгүй, албан томилолтын хуудас хаагаагүй, 5 удаагийн томилолтоор ажиллахдаа илтгэх хуудсанд нэг ижил чиглэлийн ажил гүйцэтгэснээр илтгэсэн.	2.5	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ц.Энх-Амгалан, Д.Амгалан
35	Шилэн дансны цахим хуудсанд 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	-	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ц.Энх-Амгалан, Д.Амгалан
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НДС					

**Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

36	Шилэн дансны цахим хуудсанд аудитын тайлан дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний 1 мэдээлэл, дараа жилийн төсвийн төслийн 1 мэдээллийг тус тус мэдээлээгүй.	-	Албан шаардлага	Хэлтсийн дарга, СБХОБ-ийн тасгийн дарга, нягтлан бодогч	Л.Энхжаргал, Х.Аюуш, Н.Янжиндолгор
37	Өмнөх онд өглөгөөр тусгагдаагүй 1,014.0 мянган төгрөгийн албан томилолт олгосон.	1.0	Албан шаардлага	Хэлтсийн дарга, СБХОБ-ийн тасгийн дарга,	Л.Энхжаргал, Х.Аюуш
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НДС					
38	Шилэн дансны цахим хуудсанд 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 12 хөрөнгө зарцуулах тушаалыг мэдээлээгүй.	-	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Б.Аюушжав Г.Гүррагчаа
39	Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтыг бүрэн шивэгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтын үнийн дүн зөрүүтэй.	-	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Б.Аюушжав Г.Гүррагчаа
ДОРНОГОВЬ АЙМГИЙН НДС					
40	Багаж, техник, хэрэгсэл худалдан авах зардлаас автомашинд 1,547.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авч, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан.	1.5	Албан шаардлага	Дарга, ерөнхий нягтлан бодогч	Л.Шагдарсүрэн, Б.Мөнхбат
ДОРНОД АЙМГИЙН НДС					
41	Санхүүгийн тайланд тусгагдсан нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй 102,995.4 мянган төгрөгийн авлага байна.	103.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Р.Зоригтбаатар, Б.Болортуяа
ОРХОН АЙМГИЙН НДС					
42	Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөөгүй, 5 албан хаагчид үндсэн цалингаас илүү цагийн нэмэгдэл 4,409.0 мянган төгрөгийг олгосон.	4.4	Албан шаардлага	Дарга, ахлах нягтлан бодогч	Б.Анар, Л.Эрдэнэсүвд
СЭЛЭНГЭ АЙМГИЙН НДС					
43	Сум, тосгонд байрлах нэгж хоорондын 4,079.1 мянган төгрөгийн авлага, 13,795.1 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг жилийн эцэст тооцоо нийлж, баталгаажуулаагүй.	17.9	Албан шаардлага	Дарга, Санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч	С.Отгонжаргал, Б.Бат-Орших
ТӨВ АЙМГИЙН НДС					
44	Нийгмийн даатгалын сангийн тайлангийн бусад авлагад 197,642.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, бусад өглөг 201,839.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй.	399.5	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ж.Эрдэнэжаргал Н.Отгонбаяр
ХЭНТИЙ АЙМГИЙН НДС					
45	Нийгмийн даатгалын шимтгэлийн 82.5 сая төгрөгийн авлага, 22.2 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.	104.7	Албан шаардлага	Дарга, ерөнхий нягтлан бодогч	Ц.Баярмаа, А.Эрдэнэчимэг
Дүн		18,486.1			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 603/ДО110001

Улаанбаатар хот

САГ- 2021/28/СТА-ТЄЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Байгууллага, хувь хүнээс авах 6,455.5 сая төгрөгийн авлага, 59.1 сая төгрөгийн өглөг, улсын төсвийн санхүүжилт 4,267.5 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, иргэд байгууллагуудын 1999 оноос хойш хуримтлагдсан, олон жилийн насжилттай авлага, өглөгийг шийдвэрлээгүй байна;
2. Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлт 642,589.4 сая, даатгуулагчдад ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон дэмжлэг 39,880.5 сая, нийт 682,469.9 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлд “... бусад даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан ажил олгогч болон даатгуулагч ... хүртэлх хугацаанд төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцно”, 2 дугаар зүйлд “... сайн дураар даатгуулсан нийгмийн даатгалын байгууллагатай ... сайн дураар даатгуулахаар гэрээ байгуулсан Монгол Улсын иргэний ... хүртэлх хугацаанд түүний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү орлогод ногдох тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцно.”, 3 дугаар зүйлд “... даатгуулагч ... хүртэлх хугацаанд ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200.0 /хоёр зуун/ мянган төгрөгийн дэмжлэг олгоно.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”,

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Alban Shaardlaga\2021\0426auditin 3-R Gazar60.Docx


001081422

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах, урьд онуудад хуримтлагдсан авлага, өглөгийг барагдуулах, татаас санхүүжилтийн авлагатай холбоотой асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний Аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга А.Ариунзаяа, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригт, санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ЗАНДАНБАТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 604/АОН0080

Улаанбаатар хот

САГ-2021/28/СТД-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө байршиж байгаа Чингис хаан банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банктэй холбоотой нийт 6,750.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

1. Тайлант онд гэрээнд заасан хуваарийн дагуу төлөлтүүдийг хийгээгүй;

- Чингис хаан банктэй байгуулсан 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 11/05 дугаар "Төлбөр барагдуулах гэрээ"-нд заасан хуваарийн дагуу төлөх 2,000.0 сая төгрөг,
- Үндэсний хөрөнгө оруулалтын банктэй байгуулсан 2020 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн СБГ-2 дугаар "Харилцах, хадгаламжийн данснаас зарлагын гүйлгээ хийх гэрээ"-нд заасан хуваарийн дагуу төлөх 4,750.0 сая төгрөг байна.

2. Мөнгөн хадгаламжийн гэрээнд заасны дагуу сар бүр Монголбанкнаас хянаж, тогтоосон банкны зохистой харьцааны үзүүлэлтийн мэдээг ирүүлээгүй байгаа зөрчлүүд нь нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө алдагдах, төлөгдөхгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-т "хадгалуулагчийн мөнгөн хөрөнгөнөөс зөвхөн түүний зөвшөөрөл буюу даалгавраар гүйлгээ хийх", 4-т "мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг үнэн зөв бодож, олгох", 6-д "өөрийн буруугаас учруулсан хохирлыг нөхөн төлөх", Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д "заавал байлгах нөөц, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг Монголбанкнаас тогтоосон журмын дагуу зохих хэмжээ, хэлбэрээр хангахын зэрэгцээ хадгаламж эзэмшигч, харилцагчийн мөнгөн хөрөнгийг бүрэн байлгаж, тэдгээрийн анхны шаардлагаар гаргаж өгөх, шилжүүлэх", 16.1.2-д "хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, активын эрсдэл, зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан, эх үүсвэрийн төвлөрөл, гадаад валютын болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Монголбанкнаас тогтоосон журам, шийдвэрийн дагуу биелүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Банкуудтай байгуулсан гэрээний үүргийг хангуулж, Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг хадгаламж хэлбэрээр байршуулахад холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний Аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригт, санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү нарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Ц.ЭНХЖАРГАЛ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 605/ДОН0080

Улаанбаатар хот

САГ-2021/28/СТД-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын ерөнхий газар нь төв сан, төв сангийн үйл ажиллагаа, маягтын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад хүргүүлээгүй, Нийгмийн даатгалын сангийн 2020 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т "Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайланг тайлагнаж, тушаана", Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч ... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх", 54 дүгээр зүйлийн 54.5-д "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна", 54.5.1-д "тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл (нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр), 54.5.3-т "тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл", 54.5.4-т "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/, 54.5.5-д "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тухайн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг иж бүрэн бэлтгэж, хуулиар тогтоосон хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлэх, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор гаргаж Үндэсний Аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригт, санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Ц.ЭНХЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.20\Bichig_Kherreg\Alban_Shaardlaga\2021\0426auditin 3-R Газар72.Docx

001081469



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 606/АОН0080

Улаанбаатар хот

САГ-2021/48/СТД-ТЕЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяа 26 байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд 94,843.2 сая төгрөгийн 379 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 66,631.9 сая төгрөгийн 133 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-д "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 4.1.4-д "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хуулийн хугацаанд ил тод байршуулан, зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний Аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригт, санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

АУДИТОР

Ц.ЭНХЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2021\0426auditin 3-R Gazar71.Docx

001081465



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 607/АДН0080

Улаанбаатар хот

САГ-2021/28/СТД-ТЭЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сүхбаатар дүүргийн шүүхийн 2010 оны 1615 дугаар шийдвэрээр нийгмийн даатгалын шимтгэлийн өрөнд хүлээн авсан 96.0 сая төгрөгийн үнэ бүхий 121 м.кв талбайтай үйлчилгээний зориулалттай подвал Нийгмийн даатгалын төв сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй байна. Тус подвалын үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг тухайн хуулийн этгээдээс шилжүүлэн аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Нийгмийн даатгалын өрөнд авсан эд хөрөнгийг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлж эрхийг шилжүүлж авах, авлагыг бүрэн барагдуулж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор гаргаж Үндэсний Аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригт, санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

АУДИТОР

Ц.ЭНХЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherel\Alban Shaaardlaga\2021\0426auditin 3-R Gazar70.Docx

001081462